



# СОЙЕМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№254 /463/

2023.01.26

## Цаг үе, үйл явдал

### Г.САЙХАНБАЯР: ЭНЭ ИХ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН НЬ АЛБА ХАШИЖ БАЙГАА БҮХИЙ Л АЛБАН ТУШААЛТНЫ ХАНДЛАГА, СЭТГЭЛ, УХАМСАР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭС ИХЭЭХЭН ШАЛТГААЛНА



“Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэл” сэдвийн дор явагдсан тус цугларалтад оролцсон удирдах ажилтнуудад хандаж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын хэлсэн үгийн зарим хэсгийг Та бүхэнд хүргэе.

Монгол Улсын хөгжлийн баримт бичгүүдэд Батлан хамгаалах салбарын хөгжлийг хэрхэн тусгав.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын эрхэм 9 зорилгын нэг “Амар тайван, аюулгүй нийгэм” хэмээх зорилгод “Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, үе шат тус бүрийн хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. Улмаар 2030 он гэхэд “Батлан хамгаалах тогтолцоо төгөлдөржин, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, нэгдмэл тогтолцоотой, технологичсон Зэвсэгт хүчинтэй болох” том зорилгыг дэвшүүлсэн. Энэ бол бидний алсын хараа, хүрэх үр дүн юм.

Үүний суурь, эхлэлийг зөв тавих, хөгжлийнхөө үе шатны зорилтод нийцсэн хөгжлийн төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, эдгээртэй уялдан богино хугацааны төлөвлөлтийг БХЯ, ЗХЖШ гэлтгүй захирагч, дарга бүр шат шатандаа анхаарах цаг үеийн шаардлага тавигдаж байна. Өнөөгийн байдлаар дээрх урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд туссан зорилт, арга хэмжээ нэгдээгүй өндөр хувьтай хэрэгжиж байгаа. Тухайлбал, “Алсын хараа-2050”-д туссан зорилтын 1 үе шат болох “Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе”-д туссан зорилт, 15 үйл ажиллагааны хэрэгжилт 2022 оны байдлаар 90 гаруй хувьтай байна.

Мөн УИХ-ын 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д батлан хамгаалах чиглэлээр 8 арга хэмжээг тусгуулж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл арга, хэмжээний жагсаалтад 2 төсөл, арга хэмжээг тусгуулсан ба 2022 оны байдлаар мөн 91.1 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдан батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэх” зорилтын хүрээнд 9 дэд зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2022 оны байдлаар 82.7 хувийн хэрэгжилттэй

гэж гарчээ.

Цэргийн албаны тухай хууль болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай...

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “Хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэсэн зорилт дэвшигдсэн. Энэ хүрээнд Сайдын тушаалаар Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 48 дугаар зарлигаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй хамтран ажиллах шийдвэрийг гаргасан. Уг асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд “Хугацаат цэргийн албаны тогтолцооны шинэчлэл”-ийн судалгааны даалгаврыг 2023 оны I улиралд багтаан боловсруулахаар даалгаад байна.

Хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах тогтолцоонд оновчтой, уян хатан, нийгэмд бухимдал үүсгэхгүйгээр тогтоох учиртай. Хугацаат цэргийн алба хаагч алба хааснаараа эх орноо хамгаалах цэргийн мэргэжил эзэмшихийн зэрэгцээ өнөөгийн нийгэмд хэрэгтэй наад захын мэдлэг, мэргэжилтэй, тодорхой мөнгөн хуримтлалтай, цэрэг-эх оронч үзэл, хандлагаар төлөвшсөн эр хүн болж халагдахад энэ тогтолцооны шинэчлэлийн утга учир орших болно.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай”, “Дайны байдлын тухай” зэрэг 4 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдсан.

Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулиудад цэргийн алба хаагчдын эрх зүйн байдал сайжирч, нийгмийн хамгааллын асуудлууд баталгаажих ёстойг анхаарах нь чухал.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль”-ийн хувьд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах арга хэмжээг улам тодорхой болгох учиртай.

“Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны

төлөвлөлтийг шинэчлэх” зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөсөн.

Энэ онд Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага сургалтыг Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Увс зэрэг аймгуудад явуулахаар төлөвлөж байна. Цаашид ЗХЖШ болон төрлийн цэргийн командлалуудаас зохион байгуулагдах хээрийн сургалт, дадлагыг төлөвлөхдөө Орон нутгийн хамгаалалтын хүч, хэрэгслийг оролцуулж, тэдэнтэй хэрхэн харилцан ажиллагааг зохион байгуулж явуулах талаар сургалтыг уяж өгөх нь зүйтэй.

“Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд яамд, аймаг, нийслэлээс маш өргөн хүрээтэй, олон төрөл, зүйлийн мэдээллүүдийг авч, Зэвсэгт хүчний хэрэгцээтэй уялдуулан нэгтгэх замаар дайчилгааны мэдээллийн сангийн программд шинэчлэн сайжруулалтыг хийж байна. Аймаг, нийслэл, яамдаас ирүүлсэн нийгэм, эдийн засгийн 63 багц мэдээллийг программчлах ажил 80 орчим хувийн хэрэгжилттэй явагдаж байгаа ба 2023 онд тус төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.

2023 онд цэргийн ангийн дайчилгаатай хээрийн сургуулийг орон нутгийн цэргийн нэгжийн сургалт, дадлагатай хослуулан явуулах шийдвэрийг Засгийн газрын тогтоолоор батлуулсан. Ойрын үед тушаал гаргана.

Мөн 2023 онд анхаарах гол үйл ажиллагаа бол “Боомтын сэргэлт”-ийн хүрээнд “Барилга-инженерийн цэрэг”-ийг “Богдхан” төмөр замынажилд үргэлжлүүлэн оролцуулах асуудал юм.

Зэвсэгт хүчний хувьд цэргийн нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжуудыг орчин үеийн инженерчлэлийн шийдэл бүхий “Жишиг цэргийн хотхон”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Жишиг ногоон төгөл хотхон” болгох төсөл амжилттай хэрэгжиж байгааг Та бүгд мэднэ.

Цэргийн цол, цалингийн зэрэглэлийг бүрэн шинэчилж, энэ сараас эхлэн мөрдөж эхлээд. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд цэргийн алба хаагчдын цалин, хөлсийг нэмэгдүүлэх чиглэлийг барьж ажилласан бөгөөд 2022 онд цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цол, цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулж, өнгөрөгч 2022 оны 08 дугаар сараас “Цэргийн гэрээт алба хаагч”, “Дэд ахлагч”, “Ахлагч” нарын цалинг шинэ шатлалаар нэмэгдүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолоор төрийн зарим алба хаагчид, түүний дотор төрийн үйлчилгээний болон төрийн тусгай алба хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээ дээшлэн шинэчлэн тогтоогдсон. Уг тогтоолын дагуу Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид ТТ-1-ээс ТТ-11 дүгээр шатлалаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цалинжихаар болсон.

Үүнтэй уялдуулан “Зэвсэгт хүчний алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Батлан хамгаалахын сайдын 2023 оны н/01 дүгээр тушаал батлагдаж, дунджаар цэргийн гэрээт алба хаагчийн цалин 267,534.00, ахлагч нарын цалин 250,390.00-492,270.00, офицерын цалин 214,457.00-726,105.00 төгрөгөөр тус тус нэмэгдээд байна. Мөн БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, харьяа нэгтгэл, анги, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонууд бүрэн шинэчлэгдлээ.

Батлан хамгаалах яам 2023 онд үйл ажиллагаандаа “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эх орныхоо аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлтийн эрсдэлийг тооцон төрийн батлан хамгаалах бодлогын цэргийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр ашиг, үр дүнг дээшлүүлэх” зорилгыг тавьж, дараах зорилтуудыг дэвшүүлээд байна.

Үүнд: Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, улсын дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх;

Төрийн захиргааны удирдлага, хяналтыг улам төгөлдөржүүлж, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг сайжруулах;

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний ажлын хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй шинэ шаардлагад нийцүүлэн батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг сайжруулах; Цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог чиглүүлж, өргөжүүлэн хөгжүүлэх; Зэвсэгт хүчний байлдааны шинэчлэх цэргийн техникийг шинэчлэх бодлогыг Засгийн газрын түвшинд албажуулж, хэрэгжүүлэн, цэргийн аж үйлдвэрлэл хөгжүүлэх суурийг тавих;

Цэргийн хотхоныг шинэчлэн тохижуулах, цэргийн алба хаагчдын ахуй хангалт, ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлаа санхүү, хөрөнгийн боломжоо бүрэн ашиглан үргэлжлүүлэх зэрэг болно.

Энэ их ажлын хэрэгжилт, үр дүн алба хашиж байгаа бүхий л албан тушаалтнуудын хандлага, сэтгэл, ухамсар, хичээл зүтгэлээс шууд хамааралтай юм. Иймд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний уураг тархи, зүрх болсон удирдах албан тушаалтнууд Та бүхэн маань хариуцсан байгууллагууд, нэгтгэл, ангиудынхаа үйл ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлтийг хийж, сэтгэл, зүрхээ гарган ажиллахыг хичээгээрэй. Ингээд Та бүхэндээ эх орноо батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчнээ хөгжүүлэн бэхжүүлэх эрхэм их үйлсдээ улам их амжилт гаргаж, эрүүл энх, сайн сайхан байхыг хүсэн ерөөе.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-15	-31

### ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
40	24

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,501	3,505
EUR	3,830	3,855
CNY	516	519
RUB	49.20	49.60
JPY	27.20	27.40
KRW	2.86	2.89

## ЗУРХАЙ



**ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ БИЧ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Эд мал арвижна**  
**Наран ургах, шингэх:**  
**08.27-17.42**  
**Барилдлага:**  
**Үл зохилдох**  
**Шүтэн барилдлага:**  
**Төрөн түгэхүй**

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

### Тохиолдол

Нийт: 674,122,154

### Эдгэрсэн

Нийт: 646,107,229

### Нас барсан

Нийт: 6,752,456

## “ЭЭРЭГ ХАНДЛАГА, ЭВ НЭГДЭЛ” АЯН ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Харуул үйлчилгээний тусгай ротоос “Эерэг хандлага, Эв нэгдэл” долоо хоногийн аяныг санаачилж, нээлтээ хийлээ. Аяны хүрээнд “50 номын уналт” тэмцээн, “Цэрэг миний үнэт зүйл” уран илтгэлийн тэмцээн, байгууллагын соёлыг түгээх уралдаан, сайн үйлсийн аян зэргийг зохион байгуулах ажээ.

Аяны эхний өдөр “50 номын уналт” тэмцээн явагдаж, “Аз хур” их дэлгүүрээс номын үзэсгэлэн дэлгэлээ. Мөн алба хаагчид болон хугацаат цэргийн алба хаагчдад номуудыг 20 хувийн хямдралтайгаар худалдан борлуулж, зарим алба хаагчдыг ном, дурсгалын зүйлээр шагналаа. Энэ үеэр тус ангийн штабын дарга дэд хурандаа Д.Хашхүү “Зэвсэгт хүчний бусад ангиудад үлгэр дуурал болохуйц шинэлэг үйл ажиллагааг

санаачилсан Харуул үйлчилгээний ротын бие бүрэлдэхүүндээ баяр хүргэе. Мөн манай ангийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажилласан “Аз хур” номын их дэлгүүрийн хамт олонд талархсанаа илэрхийлье. “Ном бол ертөнцийг харах цонх” гэдэг тийм болохоор та бүхэн энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаарай” гэв.

“Аз хур” номын их дэлгүүрийн идэвхжүүлэлтийн менежер Д.Дулам “Соён гэгээрэх, номтой нөхөрлөх, номын ач тусыг нэг нэгэндээ сурталчлан таниулах үйлсэд нэгдсэн танай ангийн алба хаагчидтай хамтран ажиллаж байгаадаа туйлаас баяртай байна. Цаашид ч манай компани нийгмийн хариуцлагын хүрээнд Зэвсэгт хүчинтэй хамтран ажиллахад үргэлж таатай байх болно” гэсэн юм.

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД МОНГОЛЧУУДЫН ХУВЦАСЛАХ СОЁЛЫГ СУРТАЛЧЛАВ



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд нь хугацаат цэргийн алба хаагчдынхаа ар гэрийнхэнтэй эргэх холбоотой байж, зарим төрлийн нөлөөллийн ажлуудыг хамтран зохион байгуулдаг билээ.

Энэ удаа Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчдад Монгол үндэсний өв уламжлал, хувцаслах соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор байлдагч Б.Батномингийн ээж Ц.Нэргүйцэцэг сургалт явууллаа. Үйлчин Ц.Нэргүйцэцэгийг монгол дээлээ өмсөхийн ач холбогдол, эрүүл мэнд, гоо зүйн хувьд ямар давуу тал болдгийг жишээ баримттай ярьсанд Зенитийн артиллерийн дивизионы

захирагч дэд хурандаа Б.Гэрэлтбадрал талархал дэвшүүлж, “Тусгаар тогтнол эндээс эхэлнэ” хэмээн онцолсон юм.

Сургалтын тухай Ц.Нэргүйцэцэг “Монгол дээлээ өмсөх нь хүний амьдралын жирийн асуудал мэт боловч цаад агуулгаараа олон талын ач холбогдолтой. Миний хүү шиг энэ сайхан залуус халагдаад өв уламжлалаа дээдэлж яваарай гэсэндээ хичээлээ явууллаа. Жирийн нэгэн байлдагчийн ээжид ийм боломж олгосон Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийнханд талархал дэвшүүлье” гэсэн юм.

Дэслэгч **З.ӨСӨХБАЯР**



## СУРВАЛЖЛАГЧ БАЙЛДАГЧ Б.ТӨГӨЛДӨР



Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит, Алтангадас одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангиас хугацаат цэргийн алба хаагчдын тухай хөөрхөн, хөөрхөн бичлэг, эвлүүлэг тогтмол ирүүлэх болов. Цэргийн нэг өдөр, дайчдын аав, ээжийн сэтгэгдэл, байлдагчийн индэр гээд л.

Байлдагчийн нүдээр байлдагчаа сурвалжлан гаргасан учир хөнгөн, сонирхол төрүүлэм бөгөөд энэ ажлыг санаачлан хэрэгжүүлэгч нь тус ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Бээлбаатарын Төгөлдөр ажээ. Ангийн удирдлагууд нь ч дайчныхаа хийж бүтээе гэсэн хүсэл тэмүүллийг нь өргөж, бүх талын дэмжлэг үзүүлдэг байна.

Байлдагч Б.Төгөлдөр Улаанбаатар хотынх, 24 настай. Ерөнхий боловсролын I болон “Сант” дунд сургуулийг дүүргэж, 2018-2019 онд БНХАУ-д олон улсын гадаад харилцаа мэргэжлээр суралцаж байгаад цар тахлын улмаас эх орондоо эргэн ирж. Ирсэн даруйдаа ШУТИС-д салхивч, ус дулаан хангамжийн инженер мэргэжлээр элссэн бөгөөд гуравдугаар дамжаанаасаа цэргийн албанд ирээд байгаа нь энэ ажээ.

Хичээлийнхээ хажуугаар мэргэжлийнхээ дагуу аавынхаа байгуулалцсан сантехникийн тоног төхөөрөмжийн төрөлжсөн худалдааны “Универсум” компанид борлуултын менежер хийдэг байсан гэнэ. Тэр сурч, ажиллахынхаа зэрэгцээ экстрим аялалд сонирхолтой, амьдралын идэвх өндөр, өөрийгөө шинэ бүхэнд сорьж

үздэг залуу гэдэг нь ярилцлагаас нь илт байв. Ууланд авирах, бартаат замын уралдаанд оролцохоо үндсэн ажил шигээ болгож чадсан ба үүнийгээ гар утсаараа бичиж, эвлүүлж, сошиал сүлжээндээ оруулдаг байсан нь өнөөдөр сурвалжлагч-байлдагч болгоход нөлөөлсөн байна.

Байлдагч маань мэргэжлийн камер, гар утас аль алинаар бага хэмжээний нэвтрүүлэг хийх чадвартай, өнөөгийн нөхцөлд офицер, ахлагч нарынхаа хамгийн сайн гэсэн гар утсаар дайчдынхаа бичлэгийг хийж байгаа ажээ.

Түүнд мөрдэс нэгт нөхдийнхөө тухай олон бичлэг хийхээр төлөвлөсний нэг нь “Цэргийн хоол”, “Цэргийн нөхөрлөл”, “Надад асуулт байна”, “Химичин дайчин”, “Эх орны өмнө эр хүн таны үүрэг” зэрэг олон сэдэв, санааг ажил хэрэг болгохоор дотроо “шатаж” яваагаа онцолж байсан юм.

Шинэ бүхнийг санаачлан хэрэгжүүлэгч, бүтээлч хандлагатай манай байлдагчийн аавыг Т.Бээлбаатар гэдэг, Монгол Улсын зөвлөх инженер бол ээжийг Д.Баярмаа гэдэг санхүүгийн мэргэжилтэй. Эхээс зургуулаа. Б.Төгөлдөр, Б.Түвшинжаргал, Б.Өлзий-Учрал, Б.Ван-Очир, Б.Эрдэнэ-Очир, Б.Бат-Очир гээд дөрвөн хүү, хоёр охинтой айл ажээ. Хоёр настай бага дүүгээ бага зэрэг санахаас биш цэргийн албанд уйдах завгүй суралцаад, нөхөрлөөд дөгь байна, эх орондоо тангараг өргөсөн эр цэрэг болсон би азтай гэсэн сайхан үгээр нь нийтлэлээ төгсгөө.

Ахмад **Д.БОЛОР**